

СУДАЛГАА

ТӨӨНҮҮР ЗАСАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ АРЫН БЭЛЧИРИЙН БАЙРЛАЛ,
ЗАХЫН МЭДРЭЛИЙН СУДЛЫН СУДАЛГАА

Г. Чойжамц, Ж.Амарсанаа, Б.Ууванбаатар
Оточ манрамба Их сургууль

Үндэслэл: Уламжлалт анагаах ухааны онолоортархиных далайгаас үндэс адилаар доош хатгасан үйл үйлдэгч усан судал 19 байх ба үүгээр хий гүйж биеийн хөдлөх үйлийг үйлддэг. Усан судал буюу цагаан судал нь дөрвөн мөч, цул сав эрхтэн бүгдэд оршиж хийн үйлдлээр биеийн үйл хөдлөлийг хариуцан зохицуулах чухал үүргийг гүйцэтгэдэг гэж үздэг бол өрнийн анагаах ухаанд мэдрэлийн эрхтэн тогтолцоо нь бүх эрхтэн системийн үйл ажиллагааг зохицуулан бие махбодын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг ханган гадаад орчинтой дасан зохицоход биеийг нэгэн цогц байдлаар харьцах нөхцлийг бүрдүүлдэг тогтолцоо гэж үздэг бөгөөд төөнө засал нь тусгалын нумаар өвчтэй эрхтэнд эмчилгээний ашигтай өөрчлөлт үзүүлдэг эмчилгээ юм.

Таван засал эмчилгээний нэг болох төөнүүр эмчилгээ нь биеийн гадаргуу дээрх биологийн идэвхит бэлчрээр дулааны болон эмт бодисын үйлдлийг бие махбодод дамжуулан дархлалын тогтолцоог идэвхжүүлж цус, тунгалгийн бичил эргэлтийг сэргээж, илчийг үүсгэн, хий цусны гүйдлийг тэгшитгэж өвдөлт намдаах ач холбогдолтой гэж үздэг.

Ийнхүү уламжлалт анагаах ухааны цагаан судлын салаалах ёс нь мэдрэлийн эрхтэн тогтолцооны салаалалт сүлжээнүүдийн аль нь болохыг тодорхойлон гаргаж

үүнтэй уялдуулан төөнүүр эмчилгээний арын бэлчирүүдээс тухайн аль нэг бэлчирт төөнөснөөр чухам бай эрхтэнд хэрхэн онож нөлөөлж болохыг тогтоох сонирхол төрсөн ба энэ талаар хийсэн мэдээлэл олдоогүй нь энэхүү ажлыг хийх үндэслэл болсон.

Зорилго: Төөнүүр заслын бэлчир ба захын мэдрэлийн ширхэгийн уялдаа, эмчилгээний ач холбогдолын уялдааг тогтоох.

Судалгааны ажлын арга зүй

1. Мэдээлэл цуглуулах эх бичгийн судалгааны арга

Европ болон уламжлалт анагаах ухааны ном, зохиолуудаас 31 хос мэдрэлийн нэр томъёо болон аль эрхтэнд очиж мэдрэлжүүлэх, салаалах ёс зэргийн талаар шүүж орчуулсан материалаа нэгтгэн дүгнэх.

2. Компаратив буюу харьцуулан жиших арга

Энэхүү судалгааны аргаар үндсэн хэрэглэгдэхүүн болсон УАУ болон Европ АУ-ын ном зохиол, эх сурвалжаас түүж авсан мэдээллүүдээ харьцуулан судлан үр дүнг боловсруулах.

Судалгааны ажлын үр дүн

Цагаан судлын салаалах ёсонд бие бүгдийн үндэс нь судлаас үүсэх бөгөөд

амины үндэс болох тэрхүү судал нь 2 байна. Тархинаас үндэс мэт доош хатгасан судал, хий гүйх биеийн хөдлөх үйлийг үйлддэг цагаан судал тэр нь цул савтай дотуур барилдсан 13 торгон унжлага адил далд судал, гишүүнтэй гадна барилдах 6 ил судал бөгөөд түүнээс 16 нарийн усан судал салаална.

Хэвлэлийн тойм хэсэгт уламжлалт анагаах ухааны дөрвөн үндэс болон хөх биндэрьяа сударт дотор гүйх 13 судлын хий гүйх 4 судалд зүрх, нарийн гэдсэнд тус бүр хоёр салаа очдог гэсэн бол зарим тайлбар зохиолд олгойд гэж бас нэмэгдэж гарч ирсэн. Шарын 4 судалд уушги, олгой, элэг, цөсөнд гүйх гэсэн нь тайлбар зохиолуудтай харьцуулахад яг ижил байна. Бадганы 4 судал нь ходоод, дэлүү, бөөр, давсагт гүйх гэсэн бол зарим номонд уушги нэмэгдэж бичигдсэн байсан. Гэвч хийн дөрвөн салаанд нэмэгдэж гарч ирсэн олгойн судал ганцхан номонд гарсан ба бадганы дөрвөн салаанд гарч ирсэн уушгины судал мөн ганцхан номонд тус тус гарч ирсэн тул олон давтагдсан дөрвөн судлыг авч өрнийн анагаах ухаантай харьцуулсан. Гадна гүйх 6 судал нь вүгүжин 2, жажид 2, радна 2 байдаг хэмээн хэвлэлийн тойм хэсэгт гарсан бөгөөд тайлбар зохиолууд дээрээс салаалах ёс болон хурах газрыг судалсан ба нэмэлтээр өөр байрлал заасан нэр томъёо гарсан боловч бид судалгаандаа хамгийн олон давтагдан гарсан, батлагдсан

мэдээллийг авч мөн адил өрнийн анагаах ухааны мэдрэлийн салаатай харьцуулан нугасны гадна эврээс гарах вегетатив буюу ургал мэдрэлийн зангилаа түүний салаалалтыг дотор 13 салаатай харьцуулж 10-р хос мэдрэл буюу тэнэгч мэдрэлтэй дүйцүүлсэн бол нугасны урд эврээс гарах хөдөлгөх мэдрэлийн салаа, тэр дундаа мөрний сүлжээ, бүсэлхийн сүлжээ, ууцны сүлжээг гадна гүйх 6 судалтай харьцуулсан ба мөрний сүлжээ түүнээс гарах мэдрэлийн салаануудаас *N.medialis*, *N.radialis*, *N.ulnaris* мэдрэлүүдийг байршил болон салаалалт, төгсгөлөөс нь хамааран жажид болон радна судалтай дүйцүүлсэн бол бүсэлхийн сүлжээнээс гарах *N.femoralis* мэдрэлийг вүгүжин судлын дотор салаатай, ууцны сүлжээ түүнээс гарах *N.ischiaticus* буюу суудлын мэдрэлийг вүгүжин судлын гадна салаатай байршил салаалалт төгсгөл зэргээс хамааруулан тус тус дүйцүүлэн гаргаж ирсэн.

Төөнүүрзаслын арын бэлчир, урд байрлах бэлчир, эмч олох бэлчир болон өөрөө заах бэлчрүүд ийг задлан судалвал 211 бэлчир байгаагаас арын бэлчирт байрлах гол 20 бэлчирийг авч тухайн бэлчирээс гарах мэдрэлийн салаалалт хаана очиж хэрхэн салаалж ямар эрхтэнд хүрдэг талаар судлан гаргаж ирсэн ба ингэхдээ тухайн бэлчирээс гарах нугасны хөдөлгөх мэдрэлийн салаа, ургал мэдрэлийн салааг тус тусад нь гаргаж ирсэн.

АРЫН БЭЛЧИРИЙН ТУС ЭРДЭМ, МЭДРЭЛЖҮҮЛГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

■ Таарч байгаа ■ Зарим шинж таарч байгаа ■ Дөхөм байгаа ■ Таарахгүй байгаа



Төөнүүрийн тус эрдэмтэй тухайн бэлчирээс гарах мэдрэлжүүлэг яг таарч буй 11 бэлчрийг авч хүлээн авуур түүний

үйлдэл нь тус эрдмийн ерөнхий үйлдэлтэй таарч байгаа эсэхийг судлахад дараах үр дүн гарав.



Бид төөнүүр заслын арын 20 бэлчирийн тус эрдмийг тухайн эрхтний мэдрэлжүүлэгтэй харьцуулсан ба яг таарч буй 11 бэлчрийг авч тус эрдмийг нь эрхтний хүлээр авуурын үйлдэлтэй

харьцуулахад 36% буюу дөрвөн бэлчирийн тус эрдэм хүлээн авууртайгаа таарахгүй байгаа бол 64% буюу 7 бэлчирийн тус эрдэм хүлээн авууртайгаа таарч байна.

11 Бэлчирийн тус эрдэм, хүлээн авуурын харьцуулалт

Харьцуулалт	Уламжлалт анагаах ухаан		Өрнийн анагаах ухаан	
	Бэлчирийн нэр	Тус эрдэм	Мэдрэлжүүлэх эрхтэн	Хүлээн авуур
Тохирохгүй байгаа	Хийн бэлчир	Галзуурах, сэтгэл долгиох, бие чичрэх	Зүрх	β1-Хурдасгана,
	Бөөрний бэлчир	Бөөрний хүйтэн өвчин, эрэгтэйн дусал хүйтэн гарах	Бөөр	α- Шээс багасгана.
	Цул савын ерөнхий	Хүйтэн хий, шар	Шулуун гэдэс	α, β, β1
	Бүдүүн гэдэс	Бүдүүн нарийн гэдэс хоржигнох, бэтгэ тогтох, хошногоны гүвдрүү	Шулуун гэдэс	Сулруулна, шүүрэл багасгана, гүрвэлзэх хөдөлгөөн удааширна
Тохирч байгаа	Бадган	Уушги зүрх, толгой цээжин бие өвдөх, бадган шар дэлгэрсэнд	Уушги	β ₁ -гуурсан хоолойг тэлэх
	Эх уушги	Нүднээс нулимс гоожих зэрэг нүдний өвчин, уушгинд хий бадганы өвчин	Нүд	β-Хүүхэн харааг тэлэх
			Уушги	В ₁ -Гуурсан хоолойг тэлэх
	Цөс	цөсний бэтгэ, шараар бөөлжих, идээний дуршил төрөхгүй	Элэг	β ₂ - Гликолик
	Дэлүү	Дэлүү өвдөх, ходоод хөөж хоржигнох, бие хүндрэх	Дэлүү	β ₂ - Агшина
	Самс	Дусал цувирах, цус цувирах, умайн бэтгэ, умайн гэмээр өндгөвч өвдөх, умайд хүйтэн хий дэлгэрэх,	Умайн дайвар	α-Агшина
			Төмсөг	α-Агшина
	Давсаг	Давсганд оршсон чулууны өвчин, хүйтнээр шээс чавдагшрах	Давсаг	α, β -Сулрах
	Дусал	Дусал задгайрах	Түрүү булчирхай	α-Агшаана.

Дээрх хүснэгтэд бэлчирийн тус эрдмүүдээс мэдрэлжүүлэх эрхтэнд тохирох хэсгийг авсан ба мөн тухайн бэлчирээс гарах мэдрэлжүүлгээр мэдрэлжиж буй олон эрхтнээс тухайн бэлчирт таарах гол эрхтэнг авч хүлээн авуурыг оноож харуулсан байна.

Хэлцэмж

Ийнхүү төөнүүрийн арын бэлчирээс гарах мэдрэлүүд нь хөдөлгөх болон ургал гэж хуваагдан маш олон сүлжээ үүсгэн салаалдаг болох нь харагдаж байгаа ба төөнүүр заслын эмчилгээ нь тухайн бэлчирээс гарах мэдрэлжүүлгээрээ өөр өөрийн эрхтнээс гадна олон эрхтэнд үйлчлэх боломжтой гэдэг нь харагдаж байна.

Бидний сонгон авсан төөнүүр заслын арын гол бэлчрүүдийн тус эрдмийг судлах зорилгоор эмчилгээний ач холбогдлыг судлах зорилтынхоо хүрээнд арын бэлчирт төөнөсний тус эрдмийг бэлчирээс гарах мэдрэлийн мэдрэлжүүлэх эрхтэнтэй харьцуулан үр дүн тооцоход 19 цагаан судлын салаалах ёсыг 12 хосоос тэнэгч мэдрэл, нугасны 31 хос мэдрэл, симпатик мэдрэлийн 23 зангилааны салаа байршилтай харьцуулан үзэж төөнүүр заслын бэлчирээс гарах хөдөлгөх болон ургал мэдрэлийн салаалалтыг судлан гаргаж, арын бэлчирт төөнөсний тус эрдмийг өрнийн анагаах ухааны ургал болон хөдөлгөх мэдрэлийн ёзоортой харьцуулан баталж үр дүнг тооцов.

Дүгнэлт

Төөнүүр заслын арын бэлчирт төөнөсний тус эрдмийг судлахад Андон буюу хийн бэлчир, бадган, эх уушги, цөс, дэлүү, самс, бөөр, цул савны ерөнхий, бүдүүн гэдэс, давсаг, дуслын бэлчирийн тус эрдэмтэй тухайн бэлчирээс гарах

вегетатив мэдрэлтэй эрхтнүүд таарч байна.

Өрц, элэгний бэлчирийн тус эрдэм нь мэдрэлжүүлэгтэйгээ зарим эрхтэн нь таарч зарим шинж нь мэдрэлжүүлэх эрхтэнтэй дөхөж байна.

Шарын бэлчир, ходоод, нарийн гэдэс, уруу арилгагч хийн бэлчирийн тус эрдэмтэй тухайн бэлчирээс гарах вегетатив мэдрэлийн мэдрэлжүүлэг дөхөм байна.

Хүү уушги, амин судал, зүрхний бэлчирийн тус эрдэм тухайн эрхтэндээ дам буюу тойруу замаар нөлөөлдөг гэдэг нь харагдаж байгаа ба мөн тус гурван бэлчирт төөнөснөөр ходоод, элэг, нойр булчирхай, бөөрний дээд булчирхай зэрэг олон эрхтэнд нөлөөлөх боломжтой нь харагдаж байна.

Талархал

Уг судалгааг хийхэд тусалсан ОМИС-ийн Төгсөлтийн дараах сургалтын алба, УАУ-ы тэнхим, номын сан болон МАУА-ийн акатемич, Анагаахын Шинжлэх Ухааны доктор профессор Д.Амгаланбаатар тэргүүтэй эрдэмтэн багш нартаа талархал илэрхийлж байна.

ABSTRACT

STUDY ON PERIPHERAL NERVES AND LOCATION
OF THE MOXIBUSTION POINTS ON VERTEBRAE

Chojjamts.G, Amarsanaa.J, Uuvanbaatar.B
University of Otoch Manramba

Background: According to the theory of traditional medicine, there are 19 active veins that pierce down from the brain stem like a root, through which the lhung runs and performs the movement of the body. It is believed that the water veins or white veins exist in all four limbs and solid organs and play an important role in regulating the body's activities by lhung action, while in traditional medicine, the nervous system regulates the activities of all organ systems and ensures the unity of the body's activities and adapts to the external environment. It is considered as a system that creates conditions for the body to interact as a whole, and moxibustion is a treatment that provides beneficial therapeutic changes to the diseased organ through the arc of reflection.

Purpose Establishing importance of moxibustion treatment and coherence of moxibustion points and peripheral nerve fibers.

Survey Methodology: Data collection method: 31 pairs of neurological terms from European and traditional medical books and texts, judge which organs to go to for innervation and the degree of branching of white veins and summarize the translated material

Comparative method: To develop results by comparing the data collected from the literature and sources of traditional medicine and European medicine which are the main materials of this research

Research results: The 13 inner and 6 outer veins from the white vein were filtered from traditional medical commentaries and compared with the peripheral nerve branches of the spinal cord medicine. Compared with nerve, nerve branches from the anterior horn of the spinal cord, including the shoulder, lumbar were compared with 6 fibers running outside, and from the nerve branches from the shoulder

where N. medialis, N. radialis, and N. ulnaris nerves were located and branched. According to the comparison of jajid, and Radna veins, the N. femoralis nerve coming from the lumbar with internal branches of the Vugujin vein, and the N. sciaticus or sciatic nerve coming from the lumbar were compared depending on the location of the outer branches of the Vugujin nerve and the end of the branching.

Studied how the nerves branching out from the main 20 junctions located in the posterior confluence of moxibustion therapy, and in doing so, compared the spinal nerve and vegetative nerve branches that exit from the confluence separately and assigned their locations. It is considered the feature of forming a network and separating from it to go to the innervation organ.

Conclusion: The white veins have 13 inner veins, outer veins 6, and the inner veins are 4 lhung veins, 2 heart, 2 in the small intestine, the 4 tripa (tiba) veins are in the lungs, colon, liver, and gallbladder, and the 4 badkan veins are in the stomach, spleen, kidney, bladder veins connects with vesicle of regeneration. It is mentioned in the majority of texts that it will connect with also vesicle of regeneration, but there are differences in two sources saying that 2 veins of lhung 2 in large intestine, 1 vein of badkan connects with lungs, and the 13 branches of white veins correspond to the organs innervating the vagus nerve in the medical theory. The branch of the nerve that connects with the back points of moxibustion is connected with the branch of the nerve from the anterior horn of the spinal cord, the ganglion of the sympathetic nerve from the external horn and its branches. It is considered more important to consider the branching of nodes.